



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 20

Алтай

**Цэргийн дүйцүүлэх албанд оруулах  
иргэдийн тооны хязгаар батлах тухай**

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн 12.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 102 дугаар тогтоол, Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын 6 дугаар хэсгийн 19-ийн А заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгаас 2016 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанд /татагдах/ хамрагдах сумдын иргэдийн тоог 40 хүнээр тогтоож, хавсралтаар баталсугай.

2. "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн цугларалт, сургалт явуулах, орон нутгийн бүтээн байгуулалтын ажил болон онцгой нөхцөл байдлын үед дайчлах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/, Цэргийн штабын дарга /М.Батсуурь/ нарт даалгасугай.


3. Цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлэх ажлыг ил тод нээлттэй явуулж, иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А. ДЭЛГЭРЖАРГАЛ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2016 оны 9 дүгээр сарын 25-ны  
өдрийнх дугаар тоотоллын  
хэвсгэл



№	Сум	Хамрагдах хүний тоо	Тайлбар
1	Баян-Уул	2	
2	Чандмана	4	
3	Бугат	5	
4	Тайшир	2	
5	Дэлгэр	4	
6	Тонхил	2	
7	Төгрөг	2	
8	Халиун	1	
9	Жаргалан	2	
10	Хөхморьт	3	
11	Есөнбулаг	13	
12	Дүн	40	